

ЭХ НЯРАЙ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ-II

**ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЭХНИЙ 10 САРЫН БИЕЛЭЛТ**

2025 он

Гарчиг

Нэг. Хүний нөөцийн удирдлага

Хоёр. Хүний нөөцийн төлөвлөлт

Гурав. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

Дөрөв. Шагнал урамшуулал

Тав. Сахилгын шийтгэл

Зургаа. Хүний нөөцийн сургалт

Долоо. Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ

Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Ес. Программ хангамж

Арав. Дотоод болон олон нийтийн үйл ажиллагаа

Арван нэг. Албан хэрэг хөтлөлт

Арван хоёр. Хавсралт

Нэг. Хүний нөөцийн удирдлага

Хүний нөөцийн алба нь Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төвийн дүрэм, бүтэц үйл ажиллагааны дагуу албаны дарга, хүний нөөцийн менежер 1 гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагч нарыг стандартанд заагдсан орон тоогоор, хөдөлмөрийн аюулгүй, цэвэр орчинд ажиллах, тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, ур чадвар, мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, сэтгэлзүйн болон эрүүл мэндийн нийгмийн үйлчилгээ үзүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа ил тод зохион байгуулан ажиллаж байна.

Төвд нийт 390 эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажил үүрэг гүйцэтгэсэн ба удирдах ажилтан 5, их эмч 113, эм зүйч 6, сувилагч 61, эх баригч 46, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 21, бага эмч 2, туслах сувилагч 26, эрүүл мэндийн нийгмийн ажилтан 1, эмнэлгийн бус дээд мэргэжилтэн 25, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 2, техникч 1, мэдээлэл технологийн инженер 3, бусад 78, гэрээт 6.

Мэргэжлийн зэргийн шалгалтад 1 эмч Дотрын эмчийн ахлах, Зөвлөх 1, Тэргүүлэх 1, ахлах зэргийг 2 эх баригч, тэргүүлэх 3, ахлах зэргийг 11 сувилагч нийт 19 ажилтан зэргийн шалгалтад амжилттай оролцож хамгаалсан. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу зөвлөх зэрэгт 20, тэргүүлэх зэрэгт 15, ахлах зэрэгт 10 хувийн нэмэгдлийг олгож байна.

Хоёр. Хүний нөөцийн төлөвлөлт:

Төвийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нарын орон тооны судалгааг “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS6330:2017 стандарт, болон Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/529 дугаар тушаалаар баталсан дүрэм, бүтэц орон тоо батлах тухай тушаал, Ерөнхий захирлын 2025 оны А/01 дугаар тушаалуудыг мөрдөн ажиллаж байна. 2025 онд шаардлагатай орон тооны санал өгч, батлагдсан орон тоо **500** /ТҮЭМ-372, ТҮ-128/ ажилтан.

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн, тусламж үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн мэргэжилтэн болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа **72,3%:27,6%** Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч болон эх баригч,сувилагчийн харьцаа **1:1,1**, Лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх лабораторийн их эмч, лаборант нарын

харьцаа 1:1,5 байна. Орон тооны харьцуулалт хийж үзэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтэн шатлалын стандартанд заагдсан орон тоонд хүрэхгүй байна. Үүний шалтгаан нь шинээр байгуулагдсан хотын төвөөс алслагдсан, шинэ ажилтанг гардан өлгийдөн авах тухайн тасаг албаны үйл ажиллагаа, ачаалал их зэрэгтэй холбоотой байлаа.

Гурав. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн:

Ерөнхий захирлын 2025 оны А/90 дүгээр тушаалыг мөрдөн сул болон шинэ ажлын байрны зарыг төвийн цахим хуудас, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Олон нийтийн цахим сүлжээ болон Facebookийн Эрүүл мэндийн ажилчдын нэгдсэн групп, Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II групп, Хан-Уул дүүргийн 21-р хорооны зарын групп, Буянт Ухаа-2 хороолол, Шүрт хотхоны групп, Эмч, эмнэлгийн ажилтны ажлын байр, Монголын сувилагч нарын нэгдсэн группүүдэд ажлын байрны зарыг сар бүрийн давтамжтайгаар 10 удаа шинэчлэн байршуулсан.

2025 оны байдлаар зарын дагуу 97, иргэн өөрийн биеэр 53, нийт 148 иргэний анкетыг хүлээн авч холбогдох алба, дэд захирлуудад танилцуулан сонгон шалгаруулалтын журмын дагуу ажилтанг ажилд авсан. Үүнээс

- их эмч 18,
- сувилагч 14,
- эх баригч 8,
- Туслах сувилагч 8
- Лаборант 1
- Үйлчлэгч 8
- бусад ажилтан 20
- хүүхэд асрах чөлөөнөөс орсон 4 ажилтан буюу 77 хүнийг шинээр ажилд авсан.

Ажлаас чөлөөлөгдсөн 140, үүнээс өөрийн хүсэлтээр 129, тэтгэвэрт гарсан 7, ажил олгогчийн санаачлагаар 4, жирэмсний болон амаржсаны амралт авсан 21 хүүхэд асрах чөлөө авсан 16

Төвийн нийт 390 ажилтны 260 ажилтан буюу 67 хувийг 2 жилээс дээш жил ажилласан ажилтнууд эзэлж байна.

2025 онд албан тушаал дэвшүүлэн шилжүүлсэн нийт 9

Тасгийн эрхлэгчээр 1

Туслах сувилагчаас эх баригч, сувилагч -5

Бэлтгэгч, үйлчлэгч, сав угаагч нарыг тогоочруу 3 тус тус шилжүүлсэн ажиллуулсан.

Дөрөв. Шагнал урамшуулал:

Эрүүл мэндийн яамны шагналд 27 ажилтанг нэр дэвшүүлэн холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлж

Засгийн газрын шагнал нийт

- “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” 5
- Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг” 5

Нийслэлийн Засаг даргын шагналд 3, Нийслэлийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн шагналаар 3 ажилтанг тус тус шагнаж дагалдан мөнгөн шагналд 500000 төгрөг олгосон.

Тав. Сахилгын шийтгэл:

Төвийн ерөнхий захирлын тушаалаар хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 11 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулж ганцаарчлан сануулах 5, үндсэн цалингийн 20% - 5, албан тушаал бууруулах 1 -д тус тус ажилтанд арга хэмжээ авсан байна.

Зургаа. Хүний нөөцийн сургалт

Энэ онд хүний нөөцийн сургалтыг дараах чиглэлээр бусад алба, ажилтнуудтай хамтран зохион байгуулж сургалтын танилцуулга материал 2, гарын авлага 17 гаргасан.

- **Шинэ ажилтанд зориулсан сургалт:** “Шинэ ажилтанг чиглүүлж дадлагажуулах хөтөлбөр”-ийг Ерөнхий захирлын А/134 дугаар тушаалаар батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинээр ажилд орж байгаа ажилтан, албан хаагч нарт төвийн эрхэм зорилго, үнэт зүйл, соёл, дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, ёс зүй, чанарын тухай ойлголт, стандарт удирдамж, ариутгал халдваргүйтгэл, хөдөлмөрийн аюулгүй үйл ажиллагааны талаар Сургалт гадаад харилцааны албатай хамтран 87 шинэ ажилтанд чиглүүлэх сургалтыг явуулан баталгаажуулсан байна.
- **“Хөдөлмөрийн дотоод журам”-ын танилцуулга сургалт:** 2025 оны шинээр элссэн резидент эмч болон 87 шинэ ажилтанд сургалт явуулсан.

Долоо. Төвийн ажилтнуудын нийгмийн баталгаа

- Ерөнхий захирлын тушаалаар 2025 оны эхний I, II, улиралд 315 ажилтанд үр дүнгийн мөнгөн урамшуулалд 247.062.444 төгрөг олгосон.
- 2025 оны байдлаар нийт 8 ажилтанд хавсран ажилласны нэмэгдэл 20-40 хувийн олгож байна.

Найм. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Хүний нөөцийн алба нь

- Монгол улсын хууль 9, /Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигны эсрэг хууль, Төсвийн тухай хууль гэх мэт/
- Засгийн газрын 3 тогтоол, /382, 240, 241 тогтоол,
- Төрийн албаны зөвлөлийн 3 тогтоол, /03, 600,
- Эрүүл мэндийн сайдын тушаал 5, /
- Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 1
- Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан журам 12, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилт

- Эрүүл мэндийн салбарт ажилласан 5 жил тутам 1 хоног ээлжийн амралтын хоног дээр олгох хуулийн заалтын дагуу 189 ажилтанд 1-6 хоногийн нэмэгдэл олгосон.
- 29.2 дахь заалтын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 4 албан хаагчид 80.483.034 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.

Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт :

- 2025 оны эхний 10 сарын байдлаар Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Ерөнхий захирлын Б тушаал 448, А тушаал 51 боловсруулж батлуулсан.
- Хөдөлмөрийн тухай хуулийн туршилтын хугацаагаар ажиллуулах 57 дугаар зүйлийг хэрэгжүүлэн төвд шинээр ажилд орсон туршилтын гэрээгээр ажиллаж байсан 43 ажилтантай үндсэн ажилтнаар томилон гэрээг шинэчлэн байгуулав.
- 2025 оны ээлжийн амралтыг 392 ажилтанг олгож хөдөлмөрийн тухай хуулийн нэмэгдэл хоног, эрүүл мэндийн тухай хуулийн нэмэгдэл хоногуудыг тус тус олгосон.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт:

- Гадны төрийн-2, төрийн бус-2, ААН-5 байгууллагатай хамтран нийт 5 удаагийн сурталчилгаа зохион байгуулж нийт 540 иргэн хамруулан ажилласан байна.
- Веб хуудасны Хүний нөөцийн ил тод байдал буланд постер мэдээлэл 12-ыг байршуулан эмч, ажилчид болон иргэдэд зөвлөмж мэдээллийг хүргэж тогтмолжуулсан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгээр 2025 оны 10 дугаар сарын 01-02-ны өдөр шалгуулж “Бүрэн хангалттай” үнэлгээ авсан.
- Албан хэрэг хөтлөлтийн Абле программ нь DOCX программтай холбогдсон тул төрийн байгууллагуудтай харилцан албан бичиг солилцоход илүү хялбар болсон. 2025 оны 1 сараас Байгууллагын тусгай нөхцөлтэй гэрээгээр нийт 10 албан хаагчийг дотоод сүлжээнд нэмж, ашиглалтад оруулсан.
- 2025 онд БНШК 2 удаа хуралдсан.

Ес. Программ хангамж

Хүний нөөцийн алба нь өдөр тутмын үйл ажиллагаандаа 4 төрлийн программ ашиглаж, хувь хүний мэдээллийг шивж оруулах, мэдээллийг шинэчлэх, хяналт хийх ажлыг тогтмол хийж байна.

- Энэ онд нийт 40 эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан байсныг мэдэгдэж багц цагаар 25 ажилтан, шалгалтаар 15 ажилтан тэнцэж сунгасан. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн www.hr.hdc.gov.mn цахим системд 487 ажилтан бүртгэгдсэн. Шинээр ажилд орсон нийт 54 эмнэлгийн мэргэжилтэнг бүртгэлийг шинээр хийж тогтмол хяналт тавин ажиллаж байна.
- Эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтын гэрээлэлтийн систем болох **Selectsion 1818 программд** шинэ эмч эмнэлгийн мэргэжилтэн 35 ажилтанг шинээр бүртгэл үүсгэн оруулж программ шинэчлэгдсэнтэй холбоотой нийт 352 ажилтны мэдээллийг шинэчлэн орууллаа.
- Авлигтай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийн систем meduuleg.iaас
- Цаг ашиглалтын Timely программд 77 ажилтанг шинээр бүртгэж цаг ашиглалтад хяналт тавин ажиллаж байна.

- Төрийн албаны зөвлөлийн Төрийн албаны “ХНУМТ” цахим системд ажилд орсон 77, ажлаас чөлөөлөгдсөн 111 ажилтны мэдээллийн өөрчлөлтийг оруулж ажилласан.

Арав. Дотоод, олон нийтийн үйл ажиллагаа:

- Удирдлагын шуурхай зөвлөгөөний нийт 38 удаагийн хурлын бэлтгэл ажлыг хангаж хурлын тэмдэглэл хөтлөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг танилцуулан ажилласан.
- Дэд захирлуудын зохион байгуулсан давхардсан тоогоор 40 удаагийн хуралд оролцсон.
- Спорт, урлагын тэмцээн наадамд зохион байгуулалтын ажлын хэсэг орж ажилласан.
- Бүх нийтийн их цэвэрлэгээнд 10 удаа оролцсон.
- Ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга, эцэг эхийн зөвлөлийн гишүүн, хөдөлмөрийн маргаан таслах комиссын гишүүн, Авлигатай тэмцэх газрын ЭБАТ ажилтан, архивын ажилтан зэргийг үндсэн ажлын хажуугаар хавсран гүйцэтгэж байна.

Арван нэг. Албан хэрэг хөтлөлт

2025 оны 11 сарын 19-ны байдлаар

Ирсэн бичиг 685 үүнээс хариутай бичиг 93

Явсан бичиг 612

Дээд газраас ирсэн бичиг, Эрүүл мэндийн сайдын тушаал, Албан даалгавар, Чиглэл, Тайлан, мэдээ ирүүлэх тухай, Гомдол шийдвэрлүүлэх тухай, Цахим сургалт, уулзалт, зөвлөгөөн, Эрдэм шинжилгээний бага хурал, гадаадын сургалт, хөтөлбөр, Албан шаардлага, зөвлөмж зэргийг хүлээн авч тухай бүрт хариуг хүргүүлсэн.

Ерөнхий захирлын А тушаал 50, Б тушаал 494,

Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн иргэдийн Талархал 24, Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбогдох санал гомдол 60, Захиргаа хүний нөөцийн албанд нийт 350 өргөдөл ирүүлсэнг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлж ажилласан.